



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 1/80

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/161 дугаар тушаал “Зоонозын халдварт өвчний үед ажиллах халдварт хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн заавар” гарсантай холбогдуулан Зоонозын болон бусад халдварт өвчний тархалтыг таслан зогсоох, халдвартын эрсдэлийг бууруулах чиглэлээр мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлыг боловсронгуй болгох зорилгоор ТУШААХ нь:


1. “Мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлын заавар”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү зааврыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Мэргэжлийн тусlamжийн алба /Д.Ганболд/, Эрсдэлийн удирдлага, бэлэн байдал тандалт судалгааны тасаг /Б.Дэлгэрмаа/, Ариутгал халдвартгүйтгэл, биоүйлдвэрлэлийн тасаг /Б.Хажидмаа/, Аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвүүдэд тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанар, хяналт үнэлгээ, дотоод аудитын алба /Э.Тунгалаг/, Захиргаа төлөвлөлт, хүний нөөц, статистикийн алба /Б.Амгаланбаяр/ нарт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Н.ЦОГБАДРАХ



Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
захирлын 2012 оны 11 дугаар сарын 11-ны
өдрийн 180 дугаар тушаалын хавсралт



МЭРЭГЧГҮЙТГЭЛ, ШИМЭГЧГҮЙТГЭЛ ХИЙХ АЖЛЫН ЗААВАР

Энэхүү зааврыг зоонозын өвчний үүсгэгчийг агуулж буй мэрэгч амьтан болон цус сорогчшишмэгч, дамжуулагчийг устгах үйл ажиллагаанд мөрдөж ажиллана.

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Хүн амын нягтрал ихтэй хот суурин, тэдгээрийн ойролцоо зоонозын өвчний халдвартыг агуулагч, дамжуулагч амьтдын тоо толгой ихэссэн, эпизооти идэвхитэй байгаа нь тогтоогдсон, хүн халдварт авч, өвчлөх эрсдэл үүссэн нөхцөлд мэрэгч амьтад, шимэгчийн тоошлыг бууруулах устгах, голомтын тархалтыг таслан зогсоох зэрэг арга хэмжээг зохион байгуулах нь эрсдэлээс сэргийлэх гол аргын нэг болдог.

Сүүлийн жилүүдэд эпизоотийн идэвхийг бууруулж, халдвартын эрсдэлийг багасгах ажил төсвийн хүндрэлээс шалтгаалан үр дүнтэй хийгдэхгүй байгаа нь зоонозын халдварт тэр дундаа тарваган тахал өвчний байгалийн голомт идэвхижиж хүрээгээ тэлэн, хүн ам олноор суурьшсан хот суурин газруудад тархвар судлалын хүндрэлийг үүсгэх аюул тулгарч байна.

Иймд зоонозын өвчний халдвартын голомтын тархалтыг таслан зогсоох, халдвартын эрсдэлийг бууруулах чиглэлээр мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлын арга, технологийг өөрчлөх, гүйцэтгэлийг чанаржуулах зорилгоор "Мэрэгчгүйтгэл шимэгчгүйтгэл хийх ажлын заавар"-ыг шинэчлэн боловсрууллаа.

ХОЁР. ЗОРИЛГО

Энэхүү зааврын зорилго нь зоонозын өвчний халдвартын голомтын идэвхийг бууруулах, хот суурин газар мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэл хийх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

Халдвартын эрсдэл үүссэн нөхцөл гэж хот суурин болон хүн амын нягтрал ихтэй газар, тэдгээрийн ойролцоо тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчнийг агуулагч, дамжуулагч амьтдын тоошил их, эпизооти өндөр идэвхитэй, хүн өвчлөх өндөр магадлалтай нөхцөл байдлыг хэлнэ.

Мэрэгчгүйтгэл – өвчнийг агуулагч мэрэгч, туулай хэлбэртэн амьтдын тоошлыг бууруулах;

Шимэгчгүйтгэл – өвчнийг дамжуулагч гадны шимэгчийн тоошлыг бууруулах;

Эпизооти – мал, амьтдын дунд гарсан өвчлөл

ЗӨСҮТ – Зоонозын өвчин судлалын үндэсний төв

ЗӨСТ – Зоонозын өвчин судлалын төв

АШМУХ - Ахуйн шавж, мэрэгч устгах, халдвартгүйжүүлэх

ХӨСХҮХ – Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр

ГУРАВ. ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1 Зоонозын халдвартын үед мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлыгорон нутгийн мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор ЗӨСҮТ, ЗӨСТ-өөс зохион байгуулж гүйцэтгэнэ.

3.2 Мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлыгдараах шалгуураар гүйцэтгэнэ. Үүнд:

- Тухайнөвчний халдварыг агуулагч мэрэгч амьтдын тоошил ихэссэн,
- Тухайн өвчний халдварыг дамжуулагч шимэгчийн тоошил ихэссэн,
- Эпизооти өндөр идэвхитэй нь тогтоогдсон,
- Тархвар судлалын эрсдэл үүссэн,

Дээрх шалгуураас нэг нь тогтоогдсон үед мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэл хийх үндэслэл болно.

3.3Мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлыгнэг удаагийн болон төлөвлөгөөт байдлаар зохион байгуулна. Төлөвлөгөөт устгалыг тухайн жилийн байгалийн голомт хяналтын шинжилгээний календарчилсан төлөвлөгөөнд тусгаж, ХӨСХҮХ-ийн 3.6 дугаар заалтын хүрээнд холбогдох зардлыг урьдчилан тооцож төсөвт тусган хэрэгжүүлнэ. Нэг удаагийн устгалыг тархвар судлалын заалтыг үндэслэн батлагдсан удирдамжийн дагуу ЭМ-ийн сайдын тушаалаар халдварт өвчний дэгдэлтийн бэлэн байдлын нөөц, орон нутгийн төсөв болон бусад зардлаар гүйцэтгэнэ.

3.4Хот суурин, тэдгээрийн ойролцоо зоонозын халдварын эрсдэл үүссэн тохиолдолд яаралтай хийгдэх мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлыг ахуйн шавж, мэрэгч устгах, халдвартгүйжүүлэх (АШМУХ) байгууллагууд, тухайн орон нутгийн Засаг захиргаа болон Онцгой байдлын газар, хэлтэс, ЗЭСҮТ, ЗЭСТ-ийн заавар зөвлөмжийн дагуу ажиллана.

3.5Мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлыг зохион байгуулахад зоонозын халдварт өвчний үед ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийг бүрэн хангаж ажиллана.

3.6Химиин хортой болон аюултай бодис, түүний сав баглаа, боодлыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

3.7Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүрэн хангагдсан, тэдгээр нь аюулгүй ажиллагааны болон техник ашиглалтын дүрмийн шаардлагыг бүрэн хангасан байна.

3.8АШМУХ-ын үйлчилгээнд “Ахуйн шавж, мэрэгч устгах, халдвартгүйжүүлэлт. Гуравдугаар хэсэг. Үйлчилгээ” MNS 5161-3:2002 стандартад заасан технологийн горимыг мөрдөж ажиллана.

3.9Зоонозын халдвараас сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд өвчин үүсгэгч мэрэгч, гадны шимэгчийг устгах, халдвартгүйжүүлэх арга хэмжээ нь ЗЭСҮТ-ийн захирлын тушаалаар батлагдсан журмаар зохицуулагдана.

3.10Мэрэгч болон шимэгчийн устгалд Байгаль орчин аялал жуулчлал, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан тушаалаар батлагдсан (жил бүр)экологи, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хор, бодисыг зааврын дагуу хэрэглэнэ.

3.11Энэ үйл ажиллагааг Монгол улсын амьтны тухай хууль, байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад олон улсын гэрээнд заасан холбогдох заалтын хүрээнд зохион байгуулна.

ДӨРӨВ. АЖИЛЛАХ БАГ, БҮРЭЛДЭХҮҮН

4.1 Зоонозын халдварынголомтын идэвхийг бууруулах, хот суурин газрын орон байранд мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэл хийх үйл ажиллагааг дараах баг бүрэлдэхүүнтэй хийнэ.

**Хүснэгт 1. Мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлыг хийх
баг бүрэлдэхүүн**

| Ажиллах бүрэлдэхүүн | Бүрэлдэхүүний хамгийн бага хэмжээ |
|-------------------------|-----------------------------------|
| Тархвар судлагчамч | 1 |
| Амьтансудлагч | 1 |
| Шимэгч судлагч | 1 |
| Амьтансудлалын лаборант | 1 |

| | |
|------------------------|------------|
| Шимэгчсудлалынлаборант | 1 |
| Ариутгагч | 1-2 |
| Бэлтгэмэлч | 1 |
| Жолооч | 1 |
| Нийт | 8-9 |

ТАВ. МЭРЭГЧГҮЙТГЭЛ, ШИМЭГЧГҮЙТГЭЛ ХИЙХ АРГАЧИЛАЛ

Зоонозын халдварыг агуулагч мэрэгч амьтдыг устгах мэрэгчгүйтгэл, дамжуулагч гадны шимэгчийг устгах шимэгчгүйтгэлийн ажлыг хаана хийхээс нь хамаарч **хээрийн** ба хот **суурингийн** гэж хоёр ангилаа.

5.1. МЭРЭГЧГҮЙТГЭЛ

5.1.1. Хот суурин тэдгээрийн ойролцоозоонозын халдварын голомтот нутагт эпизооти идэвхитэй нь тогтоогдсон, хүн өвчлөх эрсдэл үүссэн тохиолдолд мэрэгч амьтдын тоог цөөрүүлээд зогсохгүйтгээрийн шимэгчийг устгахад мэрэгчгүйтгэлийн ажлыгзохион байгуулна.

5.1.2. Мэрэгчгүйтгэлийг яаралтай (нэг удаагийн) болон төлөвлөгөөт байдлаар хийнэ.

- **Төлөвлөгөөт** устгалыг байнга олон удаагийн давтамжтайгаар мэрэгч амьтдын тоо толгойг бууруулахаар хийнэ.
- **Яаралтай (нэг удаагийн)** устгалыг тархвар судлалын заалтаар идэвхитэй голомтын тархалтыг богино хугацаанд таслан зогсоох үед хийнэ.

5.1.3. Мэрэгчгүйтгэлийн үйл ажиллагаанд **механик** ба **химийн** аргуудыг хэрэглэнэ. Мэрэгчдийг **механик аргаар** устгахдаа буудах, төрөл бүрийн хавх, занга, урхи, тор тавих аргуудыг ашиглана. **Химиин аргад** утаажуулагч хорт бодис болон хүнсний зүйлтэй хольсон хорт өгөөшийг ашиглана. Өгөөшийг бэлтгэхдээ **кумарин** төрлийн 0.005%-ийн концентарцтай бродифакум ба бромадилион бодисоор үйлчилдэг хорыг хүнсний зүйлтэй(будаа) хольжшингээх хэлбэрээр бэлтгэнэ. Бэлтгэсэн өгөөшөө хот суурингийн мэрэгчдийг устгахад хэрэглэнэ.

5.1.4. Хээрийн нөхцөлд жижиг мэрэгчдийн тоошлыг бууруулахад механик аргыг хэрэглэнэ (буудах, хавх, занга, урхи, тор тавих). Хээрийн мэрэгчдийг устгаж, голомтын идэвхийг бууруулах нь хүн хүч, хөрөнгө мөнгө их зарцуулдаг үр багатай байдаг.

5.1.5. Хот суурин газрын орон байрны мэрэгчдийг хавх, занга, урхи, тор тавьж устгана. Буудах аргыг хэрэглэхийг хориглоно. Бэлтгэсэн өгөөшийг хэрэглэхдээ тусгай бэлтгэсэн хайрцганд хийж, хажуу хананд нь мэрэгчид орохоор нүх гаргаж, хүн хүрэхээргүй цэгт байрлуулна. Устгалд хэрэглэсэн хор, бодисоор хоол хүнс бохирдох, хүүхэд хордохоос сэргийлж, мэрэгчгүйтгэлийн өмнөх болон дараах санамж анхааруулгыг байгууллагын удирдлага, эцэг, эх, өрхийн гишүүдэд сайтар танилцуулж, зөвлөгөө өгсөн байна.

5.1.6. Мэрэгчгүйтгэлд химийн бодисыг сонгож хэрэглэхдээ дараах зүйлийг анхаарна. **Үүнд:**

- Мэрэгчгүйтгэл хийх газрын онцлог (ямар төрлийн газар нутаг, орон сууц болох, орон байрны эрүүл ахуй-сантехникийн нөхцөл)
- Мэрэгч болон туулай хэлбэртний биологийн онцлог (төрөл, зүйл, тоо толгой, хоол тэжээлийн байдал, байршилын онцлог, тухайн хор бодисын тэсвэржилт, бусад)
- Хорт бодисын онцлог (Тухайн хор бодисын концентраци, архаг болон хурц үйлчилгээ, хэрэглэх арга, хэлбэр, хүн болон амьтанд үзүүлэх хоруу чанар, тухайн объект болон гадаад орчинд үзүүлэх нөлөө, бусад)
- Хор, бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.

5.1.7. **Мэрэгчгүйтгэлд тавигдах шаардлага:**

- Мэрэгчгүйтгэлийг мэргэжлийн баг хийж гүйцэтгэх ба тухайн цаг уурт тохирсон, хөдөлмөр хамгааллын 2-3 ээлжийн хувцас, химийн болон биологийн бодисуудын

- нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий нэг удаагийн хамгаалах хувцас хэрэглэл, анхны тусlamжийн эмийн сантай байх,
- Зоонозын өвчний үед ажиллах халдварт хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн зааврыг мөрдөх,
 - Мэрэгчгүйтгэл хийх ажиллагсад хэрэглэх хор бодисын заавартай танилцаж, аюулгүй ажиллагааны технологийг мөрдөх,
 - Химийн бодисыг зориулалтын саванд хийх, хадгалах, зөөвөрлөх,
 - Багаж, хэрэгсэлийг (хавх, занга, бусад) зориулалтын саванд хийх, халдвартгүйтгэх,
 - Мэрэгчгүйтгэлийн ажлыг зохион байгуулах багийн гишүүд нь тарваган тахлын дархлаажуулалтад хамрагдсан байх,

5.1.8. Мэрэгчгүйтгэлийн ажлын үр дүнг үнэлэх:

Мэрэгчгүйтгэлийг явуулахын өмнө ба ажилласнаас хойш 1 сарын дараамэрэгч амьтдын 1 га дахь тоошлыг гаргаж, үр дүнг хувиар илэрхийлж тооцно.

Мэрэгч амьтдыгдараах аргыг ашиглаж тоолно. **Үүнд:**

Маршрут тооллогын арга: Улий (колони) үүсгэн амьдардаг мэрэгч туулай хэлбэртнийг тоолно. Тухайн биотопд өдрийн амьдралын идэвхтэй үед нь шулуун чиглэлд 2 км урттай 10-20 метр өргөн зурваст тооллогыг хийнэ. Тооллогыг дуран ашиглан байгаа газрын нэг бүлийн дундаж, төлийн тоо, төл бүхий үлийн тоог тухай бүрд тэмдэглэж авна. Хэрэв тооллогын зурваст үлий таллаж орсон бол баруун гар талын үлийг бүртгэн авах бөгөөд зүүн гар талыг тооллогын дунд оруулалгүй орхино.

Зангаар тоолох арга: Энэ аргаар жижиг мэрэгчдийг тоолно. Тооллого хийх талбайд өгөөш бүхий 100 ширхэг зангыг хооронд нь 5 метрийн зйтай шулуун чиглэлд цувуулан тавьж хонуулан дараагийн өдрийн өглөө занганд орсон амьтны зүйлээр нь орцын хувиар тооцно.

Хавхаар тоолох арга: Зурам тархсан биотопд 0.25-0.5 га талбайн өнцгүүдэд тод харагдах зүйлээр тэмдэглэн, талбайг самнан зурамны ичээ, нүхний амсар болох цооног нүхнүүдийг бөглөнө. Зусаал нүхнүүдийг тооллогод хамруулахгүй. Дараагийн өдөр онгойсон ичээ, нүхэнд хавх зүүж орсон зурамны тоогоор 1 га дахь тоошлыг тооцож гаргана.

Хээрийн нөхцөлд мэрэгчгүйтгэл хийсэн голомтот нутагтмэрэгч амьтны тоошил 90-сдээш хувиар багассан тохиодолд, харин хот суурин газарт мэрэгч амьтад бүрэн устсан тохиолдолд үр дүнтэй гэж үзнэ.

5.2. ШИМЭГЧГҮЙТГЭЛ

5.2.1. Хот сууринтэдгээртэй ойролцоозоонозын халдвартын голомт идэвхитэй, гадны шимэгчийн халдварталт их байгаа нь тогтоогдсон, хүн өвчлөх эрсдэл үүссэн тохиолдолд шимэгчгүйтгэлийн ажлыг зохион байгуулна.

5.2.2. Шимэгчгүйтгэлийг яаралтай(нэг удаа) болон төлөвлөгөөт байдлаар зохион байгуулна.

- **Төлөвлөгөөт** устгалыг хүн ба мал, амьтан суурьшсан газарт гадны шимэгчийн тоошил ихэссэн бол жилд 2 удаа хийнэ.
- **Яаралтай (нэг удаа)** устгалыг тархвар судлалын заалтаар идэвхитэй голомтын тархалтыг богино хугацаанд таслан зогсооход хийнэ.

5.2.3. Шимэгчгүйтгэлд **химиин** аргуудыг хэрэглэнэ. Химиин аргаар устгахад пиретриод(перметрин, дельтаметрин, циперметрин, бета-ципеметрин, фенвалерат, бусад) төрлийнфосфорт органик нэгдэл сууриссан шингэн болон хуурай нунтаг, утаажуулагч хор, бодисыг хэрэглэнэ.

5.2.4. Хээрийн нөхцөлд хот суурин тэдгээрийн ойролцоо зоонозын халдвартын эрсдэл үүссэн тохиолдолд суурин газрыг тойруулан 500 метрийн хамгаалалтын бүсийг үүсгэж, эпизооттой газар нутгийн хэмжээнээс хамаарч 0.2-0.3 км² талбайд бүүрэг болон бусад гадны шимэгчийн устгалыг хийнэ. Устгалыг хийхдээ ажилтанууд гинжилсэн нэг эгнээгээр явж, мэрэгчийн нүх болгонд шингэн болон хуурай нунтаг, бодисыгмананцар үүсгэгч

аппарат болон автомаксынтусламжтайгаар (ОХУ-д үйлдвэрлэгдсэн “Твистер”, Итали улсад үйлдвэрлэгдсэн “Ранце” 10-40 кг-ийн багтаамжтай мананцар үүсгэгч) цацна.

5.2.5 Хот суурин газрынхүнсний болон хүүхдийн байгууллага, айл өрхийнцүс сорогч гадны шимэгч, хортон шавьжийг устгахад пиретриод төрлийншингэн хороор шалны хөвөө, завсар, овоолсон хог, гэрийн тэжээвэр амьтдын хэвтэш, ханыг уг уусмалаар нэвт норгон шүршиж З дээш цаг байлгасны дараа үхсэн хортон шавьж, цус сорогч гадны шимэгчийг сайтар шүүрдэж цуглуулан шатаасны дарааөрөө тасалгааны тавилга, бусад багаж хэрэгсэл, талбай зэргийг халдвартгүйжүүлэгч, угаалгын нунтаг бүхий уусмалаар угааж цэвэрлэнэ. Устгалд хэрэглэсэн бодисоор хүнс бохирдох, хүүхэд хордохоос сэргийлж, шимэгчгүйтгэлийн өмнөх болон дараах санамж анхааруулгыг байгууллагын удирдлага, эцэг, эх, өрхийн гишүүдэд сайтар танилцуулж, зөвлөгөө өгсөн байна.

5.2.6. Шимэгчгүйтгэлд химиин хор, бодисыг сонгож хэрэглэхдээ дараах зүйлийг анхаарна.

Үүнд:

- Цус сорогч гадны шимэгчийн тоошил, фенологийн үзүүлэлт, тархалт, нүх болон хөрсний механик бүтэц, дулаан, чийгшил зэргийг судалсан байна.
- Хор, бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.

5.2.7. Шимэгчгүйтгэлийн ажлыг хийх хугацааг тооцоходоо хээрийн нөхцөлд тухайн голомтот нутгийн эпизоотийн улиралчилалыг угтуулан хавар V сард хийх нь үр дүнтэй.

5.2.8. Тавигдах шаардлага:

- Шимэгчгүйтгэлийн ажлыг мэргэжлийн баг хийж гүйцэтгэн хэрэглэх хор, бодисын заавартай танилцаж, аюулгүй ажиллагааны технологийг мөрдөж ажиллах,
- Зоонозын өвчний үед ажиллах халдварт хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн зааврыг мөрдөх,
- Химиин бодисыг зориулалтын саванд хийж хадгалах, зөөвөрлөх,
- Багаж, хэрэгсэлийг (гудруул, түүз, хуруу шил, хямсаа, бусад) зориулалтын саванд хийх,
- Тухайн цаг уурт тохирсон хөдөлмөр хамгааллын 2-3 ээлжийн хувцас, хэрэглэл, анхны тусламжийн эмийн сантай байх,
- Тарваган тахлын дархлаажуулалтад хамрагдсан байх,

5.2.9. Шимэгчгүйтгэлийн ажлын үр дүнг үнэлэх:

Хээрийн нөхцөлд эпизоотийг газар нутагт шимэгчгүйтгэлийн ажлыг зохион байгуулахын өмнө ба ажилласнаас хойш 10 хоногийн дараа тус бүр 10-20 амьтан олзворлон самнаж, 30-100 нүхний амсар үзэж, 2-3 ноохой ухаж шимэгчийг цуглуулан, шимэгчийн ерөнхий нөөц, ногдоцыг хээрийн шинжилгээний арга зүйгээр гаргана. Үүнд:

Гадны шимэгчийн ерөнхий нөөцийг тогтоох: Гадны шимэгчийн ерөнхий нөөцийг үс ноолуур, ноохой, нүхний амсрын ногдоцийг хооронд нь нэмж нийлбэрээр нь тооцож гаргана.

Гадны шимэгчийн ногдоцийг тооцох: Тухайн амьтан, нүх, ноохойноос цуглуулсан шимэгчийн тоог амьтан, нүх, ноохойн тоонд хувааж ногдоцыг гаргана.

Хот суурин газарт шимэгчгүйтгэл хийхийн өмнө орон сууц, амьтны байранд наалддаг хуудас тавьж, наалдсан шимэгчийн тоог гаргана. Устгал хийсний дараа орон байрны 4 м² талбай бүрт нэг наалддаг хуудас тавьж үр дүнг тооцно. Манай нөхцөлд агнасан тарвагыг орон гэртээ оруулан өвчиж, арсыг гэртээ хадгалдагаас бүүрэг тархаж үржих нөхцөл бүрддэг.

Шимэгчгүйтгэлийн үр дүнг дараах томъёогоор бодож гаргана.

$$\text{Устгалын үр дүн } (\%) = \frac{(N_1 - N_2)}{N_1} \times 100$$

N₁ - устгал хийхээс өмнөх шимэгчийн тоо

N₂ – устгал хийсний дараах шимэгчийн тоо

Хээрийн нөхцөлд шимэгчгүйтгэл хийсэн голомтот нутагт бүүрэгний тоошил 90-с дээш хувиар багассан тохиолдолд үр дүнтэй гэж үзнэ. Харин хот суурин газарт шимэгч бүрэн устсан тохиолдолд үр дүнтэй гэж үзнэ.

Устгалын ажлын үр дүнг 1 сараас дээш хугацааныдараа тооцно. Хэрэв үр дүн бага бол давтан хийнэ.

ЗУРГАА. ХИМИЙН БОДИС АСГАРСАН, ЦАЦАГДСАН, ХОРДСОН ҮЕД ҮЗҮҮЛЭХ АНХНЫ ТУСЛАМЖ

6.1 Хор, бодистой ажиллахдаа эм, хэрэгсэл бүхий яаралтай тусlamжийн хайрцаг зайлшгүй байлгаж хяналт тавьж ажиллана(Хүснэгт 2).

6.2 Хор, бодисууд нь хамар, залгиур хоолой, бронхын салст бүрхүүлийг цочроосноор хамраас нус гоожих, хуурай ханиалгах, нүд хорсох, загатнах, нулимс асгарах, хүнд хордсон үед амьсгаадах, цээжний араар өвдөх, дотор муухайрах, бөөлжих зэрэг шинж илэрч болно.

6.3 Хор, бодисонд хордсон тохиолдолд яаралтай авах арга хэмжээ:

- Хордсон газраас яаралтайхолдуулж, цэвэр агаараар амьсгалуулна.
- Хор, бодис асгарч, цацагдсан хувцсыг тайлуулж, бодисыг хөвөн даавуугаар зөөлөн арчиж, шингээж авах ба үрж нухаж болохгүй.
- Арьсыг 5-10%-ийн нашатырын спирт эсвэл 2%-ийн содын уусмалаар цэвэрлэнэ. Хэрэв дээрхи бодисууд байхгүй бол арьсыг савантай урсгал усаар угааж цэвэрлэнэ.
- Нүдэнд химийн бодис орсон бол урсгал цэвэр усаар эсвэл 2%-ийн хүнсний содын уусмалаар 5-10 минутын туршид угаана. Хэрэв нүдний салстад цочрол их өгсөн бол альбуцидын уусмалаар зайлах ба өвдөлттэй байвал 2%-ийн новокайны уусмал хэрэглэнэ. Хүүхэн хараа нарийсаж, харааны хямрал өөрчлөлт илрөвэл 0.05%-ийн хүхэр хүчлийн атропин эсвэл 0.1%-ийн атропиныг устай 1:1 харьцаагаар хольж зайлах байдлаар угаана.
- Залгиурын салст цочирсон бол 2%-ийн хүнсний содын уусмал уулгах эсвэл содын уусмалаар утах, ханиалгаад байвал гич, бумба тавьж болно.
- Химийн бодисыг санамсаргүй тохиолдоор залгисан бол цэвэр ус эсвэл марганцийн цайвар ягаан өнгийн /1:5000, 1:10000/ уусмалаас уулгаж, дараа нь бөөлжүүлнэ. Бөөлжүүлэхийн тулд цочроо янз бүрийн аргыг хэрэглэж болно. Үүнд: механик цочрол (хүүхэн хэл, хэлний угийг цочроо), гичийн тусlamжтайгаар (нэг стакан бүлээн усанд 1 цайны халбага хуурай гич хийх) цочроож, энэ ажилбарыг 2 удаа давтана. Бөөлжсөний дараа ходоодыг 2%-ийн хүнсний содын уусмалаар (1 стакан усанд нэг цайны халбага сод хийнэ) угаана.

Хүснэгт 2. Анхны тусlamжийн эм, хэрэгсэл

| № | Эмийннэр | Тоохэмжээ |
|----|-----------------------------|-----------|
| 1 | Альбуцид 30% уусмал | 1 фл |
| 2 | Атропин 0.1% | 50 амп |
| 3 | Идэвхижүүлсэннүүрс | 500.0 |
| 4 | Аммиак 10% (нашатырынспирт) | 100.0 |
| 5 | Валериан (ханд, шахмал) | 1 фл |
| 6 | Марганец | 500.0 |
| 7 | Кальцийхлорид | 200.0 |
| 8 | Марганцкали | 50.0 |
| 9 | Ургамлынтос | 200.0 |
| 10 | Зэсийн сульфат | 50.0 |
| 11 | Новокайн 2% | 20.0 |
| 12 | Хүнснийсад | 200.0 |
| 13 | Устөрөгчийнхэтисэл | 1 фл |

| | | |
|----|--|-----------|
| 14 | Сулруулсандавс | 50.0 |
| 15 | Зүрхнийбэлдмэл | 2 фл |
| 16 | Гич | 50 ширхэг |
| 17 | Нүднийдусаагуур | 3 ширхэг |
| 18 | Нүдугаахзориулалтын төхөөрөмж эсвэл том амсартай сав | 1ширхэг |
| 19 | Ариунбинт | 10 ширхэг |
| 20 | Хөвөн | 100.0 |
| 21 | Иод | 100.0 |

ДОЛОО. ХЯНАЛТ ТАВИХ

7.1. Мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн үйл ажиллагааг тархвар судлагч эмчийнхяналтад хийж гүйцэтгэнэ.

7.2. Ажиллах явцад багийн гишүүдэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчний сэжигтэй шинж тэмдэг илэрсэнтохиолдолд харьяа удирдлагадяарлтай мэдэгдэж, холбогдох хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.3. Зоонозын өвчний үед ажиллах халдварт хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн зааврыг мөрдөж ажиллаагүйн улмаас зөрчил, осол гаргасан үед холбогдох арга хэмжээг авна.

НАЙМ. ТАЙЛАН БИЧИХ ДАРААЛАЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

8.1 Ажлын тайланг анхан шатны бүртгэлийн хамт мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлын үр дүнг тооцсоны дараазааврындагуубичиж ЗӨСҮТ-д цахимаарболонцаасаар ирүүлнэ.

8.2 Ажлын шуурхай мэдээг(Хүснэгт 3)14хоногт багтаан ирүүлсэн байна. Мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлын тайланг доорх дарааллаар бичнэ. **Үүнд:**

1. Ажлын удирдамж
2. Ажилласан бүрэлдэхүүн
3. Үндэслэл шаардлага
4. Голомт нутгийн тойм
5. Мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлын үр дүн
6. Хор, бодисын нэр, зарцуулсан хэмжээ
7. Дүгнэлт
8. Хавсралт хүснэгт
9. Ажлын зураг

Ажилласан хугацаа, бүрэлдэхүүн хэсэг:

Халдварын эрсдлийг бууруулах хэлбэрийг (мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэл) тодорхойлж, хамрах талбайн хэмжээг тооцно.

Үндэслэл, шаардлага:

Хот суурин газар болон тарваган тахлын эпизооти идэвхитэй, хүн өвчлөх эрсдэлтэй голомтот нутагт тархвар судлалын заалтыг үндэслэн мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийг урт, богино хугацааар хийх шаардлагыг тусгасан байна.

Голомтот нутгийн тойм хэсэгт:

Тухайн голомтын ангилал, талбайн хэмжээ, хамрагдах газрын нэрс, секторын дугаарыг бичихээс гадна голомтын биоценозын бүтэц, өмнөх онуудад хийгдэж байсан эпизоотологийн шинжилгээ, халдвартай болон эпизооттой талбайн хэмжээ, эпизоотын идэвхжилийн онцлог, хүний өвчлөл гарч байсан эсэх гэх мэт голомтын төлөв байдлын талаар хүндсэн онцлог талуудыг товч тоймлон дурдсан байна.

Мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлын үр дүнгийн хэсэгт:

- Шимэгчийн тоошлыг бууруулж, устгах арга, хэлбэр, аргачилал, хор, бодисын талаар тодорхой бичнэ.
- Мэрэгч амьтдын 1 га дахь тоошлыг устгалын өмнө, хойно тооллого хийж, үр дүнг харьцуулан хувиар илэрхийлж тооцсон байна.

- Голомтот нутагт шимэгчгүйтгэлийн өмнө ба дараа ньмэрэгч амьтад, нүх, ноохойноосцуулсан гадны шимэгчийн ерөнхий нөөц, ногдоцыг гаргаж, үр дүнг тооцсон байна.

Дүгнэлтийн хэсэгт: Мэрэгч амьтад тэдгээрийн гадны шимэгчийн тоо толгойг бууруулж, устгасан ажлын үр дүнг үнэлэх

8.3 Холбогдох анхан шатны бүртгэлийг төвийн захирлын 2017 оны А/07 тоот тушаалар батлагдсан тарваган тахал түүнтэй хам тохиодлох халдварт өвчний байгалийн голомтын тандал судалгааны зааврын дагуу гаргаж, тайланд хавсаргасан байна.

**Хүснэгт 3. аймаг, нийслэлийн ЗӨСТ-ийн хийсэн мэрэгчгүйтгэл,
шимэгчгүйтгэлийн ажлын шуурхай мэдээ**

| № | Гүйцэтгэх ажил | | | Гүйцэтгэл |
|---|------------------|----------------------------|-------------------|-------------------|
| 1 | Хийгдсэн хугацаа | Эхэлсэн огноо | | |
| | | Дууссан огноо | | |
| 2 | Хийгдсэн | Сумын нэр | | |
| | | Газрын нэр | | |
| 3 | Мэрэгчгүйтгэл | Секторын дугаар | | |
| | | Талбайн хэмжээ | | |
| | Шимэгчгүйтгэл | Агуулагчийн тоошил | | |
| | | Агнасан амьтны тоо | | |
| | | Сийрэгжилтийн хувь | | |
| | | Секторын дугаар | | |
| | | Талбайн хэмжээ | | |
| 4 | Устгалын өмнө | Үзсэн нүхний амсрын тоо | | |
| | | | Нүхний амсраас | Бүүрэг |
| | | | | Хачиг |
| | | | | Бүгд |
| | | | Үс ноолуураас | Агнасан амьтан |
| | | | | Бүүрэг |
| | | | | Беес |
| | | | | Хачиг |
| | | | Ухсан ноохой | Бүгд |
| | | | | Ноохойноос |
| | | | | Бүүрэг |
| | | | | Бүгд |
| | Устгалын дараа | Дамжуулагчийн ерөнхий нөөц | | |
| | | | Нүхний амсрын тоо | Нүхний амсрын тоо |
| | | | | Бүүрэг |
| | | | | Хачиг |
| | | | | Бүгд |
| | | | Үс ноолуураас | Агнасан амьтан |
| | | | | Бүүрэг |
| | | | | Беес |
| | | | | Хачиг |
| | | | Ухсан ноохой | Бүгд |
| | | | | Ноохойноос |
| | | | | Бүүрэг |
| | | | | Бүгд |
| | | Дамжуулагчийн ерөнхий нөөц | | |
| | | | Үр дүн (%-р) | |

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Чипанин Е.В., Корзун В.М., Никитин А.Я., Михайлов Е.П., Денисов А.В., Фомина Л.А., Абибулаев Д.Э., Санаров П.П., Филатов Е.И., Шеффер В.. (2017). Методические рекомендации по регуляции численности носителей и переносчиков чумы на территории Горно-Алтайского высокогорного природного очага. ФКУЗ <Иркутский научно-исследовательский противочумный институт>, ФКУЗ <Алтайская противочумная станция>, Иркутск, с8-18.
2. С.В.Балахонов., В.М. Корзуна..(2014) Горно-Алтайский природный очаг чумы. Новосибирск наук центр.
3. Б.М. Сулейменов ., (2009) энзоотия и эпизоотия чумы , -Монография, алматы.
4. Цэрэнноров Д., Батжав Д., Болормаа Г., Хишигсүрэн Н. (2004). Хээрийн шинжилгээний арга зүй.
5. Хишигсүрэн Я. (2001). Тарваган тахлын байгалийн голомтын шимэгчгүйтгэлийн ажлын тойм. БГХӨЭС Төвийн эрдэм шинжилгээний бүтээл, №9, Улаанбаатар, х 225-241.
6. Батцэцэг Ж., Цэрэнноров Д. (2008). Голомтын идэвхийг бууруулж, халдварын эрсдлийг багасгаж ирсэн ажлын дүнг судалсан нь. БГХӨЭС Төвийн эрдэм шинжилгээний бүтээл, №12, Улаанбаатар, х 326-331.
7. Байгаль орчин аялал жуулчлалын сайд, хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал. (2017). Монгол улсад 2017 онд ашиглаж болох ахуйн хортон шавьж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисын цагсаалт хэрэглэх хэмжээ.
8. www.Irknipvhi.ru/index.htm
9. Чулуунбаатар Ц., Адъяасүрэн З., Батболд Ж. (2000). Тарваган тахал тэмцэх арга. БГХӨЭСТ, Улаанбаатар, х 98-103.
10. "Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт. Гуравдугаар хэсэг. Үйлчилгээ" MNS 5161-3:2002 стандарт
11. Тарваган тахлын байгалийн голомт дахь халдварын эрсдлийг бууруулах ажлын заавар. ЭМС-ын 2006 оны 114 тоот тушаалын II хавсралт